

2025 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

**Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн бүтэц, зохион
байгуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1 дэх заалт, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.2 дахь заалт, Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц”-ийг энэхүү тогтоолын хавсралтын дагуу шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллах, дотоод зохион байгуулалт хийхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан Худалдаа, хөгжлийн банканд мөрдөгдөж буй холбогдох заавар, журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоол мөрдөгдөж эхэлсэн өдрөөс Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 10-тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА



TRADE AND DEVELOPMENT BANK OF MONGOLIA ORGANIZATIONAL STRUCTURE



2025 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээс чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, 8.11.26 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хараат бус гишүүн Жамсрандоржийн Дэлгэрсайхан нь хараат бус гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт ирүүлсэн тул хүсэлтийг хүлээн авч, энэхүү тогтоол гарсан өдрөөр хараат бус гишүүнээс чөлөөлсүгэй.

2. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлох холбогдох хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан этгээдийг сонгон шалгаруулж, ТУЗ-ийн хуралд танилцуулах, түр томилуулахыг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо (Ж.Болормаа)-нд даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах, холбогдох мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА